



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/499

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.6-ын "г", "л", Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн 16 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөшөөт төслийн 2021 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөө, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг нягтлан шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: А.Жамъянсүрэн - Мэргэжлийн Хяналтын газрын хэлтсийн дарга, улсын ахлах байцаагч

Гишүүд: Т.Бямбажаргал - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн

Н. Алтанцэцэг - Мэргэжлийн хяналтын газрын уул уурхай хариуцсан хяналтын улсын байцаагч

Б. Ганзориг - Мэргэжлийн хяналтын авто замын хяналтын улсын байцагч

Н. Батболд - Дарви сумын Байгаль орчны хяналтын улсын байцагч


Нарийн бичгийн

дарга: Х.Мөнхжаргал - Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч

2. Хөшөөт төслийн 2021 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөө, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг нягтлан шалгаж, дүгнэлт гарган тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч /А.Жамъянсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ